



ЭРСДЭЛЭЛТИЙН ИРЭЭДЭҮЙНЭ БАТАЛГАА

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо: 2023.12.28

№ 106


Улаанбаатар хот

### Зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, "Төрийн банк ХК-ийн Сонирхлын зөрчлийг зохицуулах журам"-ын 3.4 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 14 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрдэнэс таван толгой" ХК-иас дотоодын зах зээлд гаргасан төгрөгийн бондыг "Төрийн банк" ХК-д худалдах талаар Монгол Улсын Хөгжлийн банкнаас ирүүлсэн саналыг зохих хууль тогтоомж, холбогдох журмын дагуу банканд ашигтай, хамгийн бага эрсдэлтэй байх нөхцөлөөр 40.0 тэрбум төгрөг хүртэлх хязгаарт багтаан, худалдан авах хэлцэл хийхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д зөвшөөрсүгэй.
2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Б.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН